ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Тосонцэнгэл сумын Тохижилт үйлчилгээний албаны 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ЗАА-2022/06/СТА-ОНӨААТҮГ

Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын
тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа
Утас: 99993365
Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn

Аудитын менежер : Б.Дагвасүрэн
Утас:99014227
Цахим хаяг: dagvasurenb@audit.gov.mn

Аудитор Б.Жалбаа
Утас: 89330330
Цахим хаяг: jalbaab@audit.gov.mn

Цахим хуудас: www.audit.mn

Улиастай сум

2022 он

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт 2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан 4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан 4
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан 4
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан 4
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан 5
2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл 5
3. Санхүүгийн тайлангийн тодруулга ..... **Error! Bookmark not defined.**
3.1 Байгууллагын үйл ажилагаа 6
3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин 6
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого 6
4. Аудитын тайлан 6
4.1 Ерөнхий зүйл 7
4.2 Дотоод хяналт 8
4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал 8
4.4 Материаллаг байдал 8
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал 8
5.1 Шилэн дансны мэдээлэл 8
6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт 9
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал 9
8. Аудитын илрүүлэлт 9
8.1 Залруулсан алдаа 9
8.2 Төлбөрийн акт 9
8.3 Албан шаардлага 9
8.4 Зөвлөмж 9
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл 0

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.Аудитын санал дүгнэлт

ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
81090 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс:7046-36-12

2022. 03. 15 № 1302/426

танай _____-ны № _____-т

ТОСОНЦЭНГЭЛ СУМЫН
ТОХИЖИЛТ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
АЛБАНЫ ДАРГА Д.ГАНЦООЖ-Д

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Тосонцэнгэл сумын Тохижилт үйлчилгээний албаны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Тосонцэнгэл сумын Тохижилт үйлчилгээний албаны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын батлсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

01202547З

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.БАТ-УНДРАА

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/мян.төг/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	85.2	482.5
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага		711.0
1.1.4	Бусад авлага		159.0
1.1.6	Бараа материал		8,271.7
1.1.7	Урьдчилж төлсөн зардал		2,000.0
1.1.11	**Эргэлтийн хөрөнгийн дүн**	**85.2**	**11,624.2**
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө		114,601.7
1.2.9	Хуримтлагдсан элэгдэл		-9,759.1
1.2.10	**Эргэлтийн бус хөрөнгийн дүн**		**104,842.6**
1.3	**НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН**	**85.2**	**116,466.8**
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн		
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн		
2.2	**Өр төлбөрийн нийт дүн**		
2.3	Өмч		
2.3.1	Төрийн		114,601.7
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг		8,271.7
2.3.9	Хуримтлагдсан ашиг	85.2	-6,406.6
2.3.11	**Эздийн өмчийн дүн**	**85.2**	**116,466.8**
2.4	**ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН**	**85.2**	**116,466.8**

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

/мян.төг/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого	84,966.2	150,789.4
2	Борлуулалтын өртөг	84,881.0	147,522.1
3	**Нийт ашиг/алдагдал**	**85.2**	**3,267.3**
11	Элэгдлийн зардал	0	9,759.1
18	**Татвар төлөхийн өмнөх ашиг/алдагдал**	**85.2**	**-6,491.8**
20	**Татварын дараах ашиг/алдагдал**	**85.2**	**-6,491.8**
22	**Тайлант үеийн цэвэр ашиг/алдагдал**	**85.2**	**-6,491.8**

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/мян.төг/

Үзүүлэлт	Өмч	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл					**85.2**	**85.2**
Залруулсан үлдэгдэл					85.2	85.2
Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал					-6491.8	-6,491.8
Өмчид гарсан өөрчлөлт	114,601.7			8,271.7		122,873.4

2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	**114,601.7**			**8,217.7**	**-6,406.6**	**116,466.8**

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мян.төг/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1.1	**Мөнгөн орлогын дүн**	**84,966.2**	**150,789.4**
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	70,300.0	80,000.0
1.1.6	Бусад мөнгөн орлого	0	70,789.4
1.2	**Мөнгөн зарлагын дүн**	**84,881.0**	**148082.1**
1.2.1	Ажиллагчдад төлсөн	42,000.0	45,439.6
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	11,320.0	14,317.5
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	7,800.0	10,271.7
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	6,000.0	4,927.2
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	13,400.0	41,444.6
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	2,928.5	3,509.0
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	108.9	108.9
1.2.9	Бусад мөнгөн зарлага	1,323.6	28,024.6
1.3	**Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн**	**85.2**	**2,707.3**
2	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
2.1	Мөнгөн орлогын дүн		
2.2	**Мөнгөн зарлагын дүн**		**2,310.0**
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		2,310.0
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		-2,310.0
3	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
3.1	Мөнгөн орлогын дүн		
3.2	Мөнгөн зарлагын дүн		
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		
4.1	**Бүх цэвэр мөнгөн гүйлгээ**	**85.2**	**397.3**
5	**МӨНГӨ ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ**	**0**	**85.2**
6	**МӨНГӨ ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ**	**85.2**	**482.5**

2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2019 оны гүйцэтгэл	2020 оны			
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулаагүй байна.						

3. Санхүүгийн тайлангийн тодруулга

3.1 Байгууллагын үйл ажиллагаа

Тосонцэнгэл сумын Тохижилт үйлчилгээний албаны зорилго нь төсвийн болон хувийн хэвшлийн аж ахуй нэгж албан байгууллага, айл өрхийн хог тээвэрлэх, устгах, төвлөрсөн хогийн цэгийн хогийг эмх цэгцтэй байлгахад оршино. Компанийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг сумын төвийн тохижилт цэцэрлэгжүүлэлт, гудамж талбайн гэрэлтүүлэг, нийтийн эзэмшлийн зам талбай, цэцэрлэгт хүрээлэнг арчилж хамгаалах гэж тодорхойлжээ.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар гэсэн статустай байна. Өмчийн 100 хувийг төр эзэмшиж байна.

3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Тосонцэнгэл сумын Тохижилт үйлчилгээний албыг Тосонцэнгэл сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 48 дугаар тогтоолыг үндэслэн сумын Засаг даргын захирамжаар байгуулсан бөгөөд сумын засаг даргын тамгын газрын дэргэд үйл ажиллагаагаа явуулж байсан байна.

ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг Тосонцэнгэл сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 86 дугаар тогтоолоор томилсон байна. Ингэхдээ Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшуулллыг тогтоогоогүй байна.

Монгол Улсын Засгийн газрын "2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 4.4.10-т "Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно." гэж заасан байна. Энэ хүрээнд Тосонцэнгэл сумын Тохижилт үйлчилгээний албыг бие даасан байгууллагын хэлбэрт шилжүүлсэн байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Тосонцэнгэл сумын Тохижилт үйлчилгээний албаны санхүүгийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс батлагдсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган.төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	85.2	482.5	400.0
БХХО			
Авлага		870.0	870.0
Урьдчилгаа		2,000.0	2,000.0
Бараа материал		8,271.7	8,271.7
Үндсэн хөрөнгө		104,842.6	104,842.6
Биет бус хөрөнгө			
Нийт хөрөнгийн дүн	**85.2**	**116,466.8**	**116,381.6**
Эздийн өмч	85.2	116,466.8	116,466.8
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	**85.2**	**116,466.8**	**116,466.8**

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд 482.5 мянган төгрөг нь кассын үлдэгдэл 169.0 мянган төгрөг, харилцах даны үлдэгдэл 313.5 мянган төгрөгийн үлдэгдэл байна.

Авлагын үлдэгдэлд татвар, НДШ-ийн авлага 711.0 мянга, бусад авлага 159.0 мянган төгрөгийг эзэлж байна.

Тайлант онд байгаль орчны үнэлгээ хийлгүүлэх ажлын төлбөрт 2,000.0 мянган төгрөгийн урьдчилгаа шилжүүлсэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 8,271.7 мянган төгрөг болж өссөн нь сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар тухайн байгууллагад машины граж барих ажил хийхээр төлөвлөсөн ч санхүүжилт нь оройтож ирсний улмаас тус ажил хийгдээгүй байна. Тухайн ажилд шаардагдах материалыг бэлтгэсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө нь тайлант онд худалдан авалтаар 2,310.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, сумын ЗДТГ-аас үнэ төлбөргүй хүлээн авсан 112,291.7 мянган төгрөгийн авто тээврийн хэрэгсэл зэрэг хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Санхүүгийн тайланд зардал өртгийн талаарх мэдээллийг бэлтгэх зорилгын дагуу үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүний өртөг, үйл ажиллагааны зардал, үйл ажиллагааны бус зардал гэж ангилсан байна. Зардал өмнөх онтой харьцуулахад 62,641.1. сая төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант онд бие даан үйл ажиллагаа явуулсан, ОНХС-ийн хөрөнгөөр гэрээний үндсэн дээр зам засвар, гэрэлтүүлгийн ажил хийсэн зэрэгтэй холбоотой байна.

3.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу гүйцэтгэх удирдлага байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Гэтэл тус байгууллага үйл ажиллагааны тайлан төлөвлөгөө боловсруулж ажиллаагүй байна.

4. Аудитын тайлан

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Тосонцэнгэл сумын Тохижилт үйлчилгээний албаны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад санхүүгийн аудитаар илэрсэн алдаа зөрчилтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Жалбаа гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер Б.Дагвасүрэн , дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар тус тус хэрэгжүүлсэн.

Тосонцэнгэл сумын Тохижилт үйлчилгээний алба 2021 оны санхүүгийн тайланг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 04 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Дотоод хяналт

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна гэж үзсэн. Тус байгууллага нь сумын ЗДТГ-ын харьяанд үйл ажиллагаа явуулж байгаад 2021 онд бие даасан хэлбэрт шилжсэнтэй холбоотой дотоод хяналтын нэгжийг байгуулаагүй байна. Мөн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулаагүй байна.

4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Тосонцэнгэл сумын Тохижилт үйлчилгээний алба 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл суурьяр хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

4.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл "дунд" гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны мөнгөн орлого 150,789.4 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 1,507.9 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус байгууллага үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тосонцэнгэл сумын Тохижилт үйлчилгээний алба нь тайлант онд нийт 150,789.4 мянган төгрөгийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаар байна. Гэтэл цахим мэдээллийн системд мэдээлэл оруулах зэсийг үүсгээгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 "Байгууллага нь шилэн дансны мэдээллийг өөрийн цахим хуудсаар хүргэх бөгөөд цахим хуудас нь дараах шаардлагыг хангасан байна", 5.1.1 "шилэн дансны бие даасан цэстэй байх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим мэдээллийн санд мэдээлэл оруулах зэсийг үүсгэх зөвлөмж хүргүүллээ.

5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой алдаа зөрчил илрээгүй

6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тус байгууллагын үйл ажиллагаанд завсрын аудит хийгдээгүй байна.

7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татсан асуудал ажиглагдаагүй болно

8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 822.1 мянган төгрөгийн 5 алдаа зөрчил илэрснээс, 822.1 мянган төгрөгийн 1 алдааг залруулж, 4 зөрчилд зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй алдаа зөрчил нь тогтоосон 1,507.9 мянган төгрөгийн түвшнээс бага байгаа тул "Зөрчилгүй" санал дүгнэлт өглөө.

8.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 822.1 мянган төгрөгийн 1 алдааг залрууллаа. Үүнд:

- Санхүүгийн тайланд өглөгийг 81.3 мянган төгрөгөөр илүү, авлагыг 740.8 мянган төгрөгөөр дутуу тусгасан байна.

8.2 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоох алдаа зөрчил илрээгүй

8.3 Албан шаардлага

Албан шаардлага өгөх алдаа зөрчил илрээгүй

8.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой асуудал

Илрүүлэлт: 2021 онд байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулаагүй, төсөв батлаагүй үйл ажиллагаа явуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3 "төрийн өмчит хуулийн этгээдээс дагаж мөрдөх төлөвлөлт, ашиг орлогын хуваарилалтыг холбогдох байгууллагатай тохиролцон тогтоох", 20 дугаар зүйлийн 20.1.3 "үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан баталж, тухайн тайланд онд орох орлого, зардлын төсвийг ТУЗ-өөр батлуулан мөрдөж ажиллах

2. Бүтэц орон тоо, цалингийн сантай холбоотой асуудал

Илрүүлэлт: Байгууллагын бүтэц орон тоо, цалингийн санг нарийвчлан тогтоогоогүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.9.дэд шатны төсвийн захирагчийн зөвшөөрснөөр үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтцийг батлагдсан орон тооны хязгаар, төсвийн хүрээнд шинэчлэн тогтоох гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Байгууллагын бүтэц орон тоо, цалингийн санг нарийвчлан тогтоож мөрдөж ажиллах

3. Байгууллагын үйл ажиллагааны орлого бүрдүүлэлттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Байгууллагын үйл ажиллагааны орлогыг данс бүртгэлд тушаагаагүй байна. Энэ нь Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар батлагдсан Төсөвт байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журмын 2.6 "Төсвийн байгууллага үндсэн болон туслах үйл ажиллагаа (бусад орлого)-наас орох орлогыг мөнгөн касстаа бэлнээр хүлээн авч энэхүү орлогыг / түүнийг шууд захиран зарцуулах эрхгүй / ажлын дараагийн өдөрт багтаан кассын нярав Төрийн сан дахь бүртгэлийн дансанд тушаана" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогыг харилцах дансанд тухай бүр тушааж байх.

4. Шилэн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Шилэн дансны тухай хуулийн дагуу шилэн дансны цахим сайтад мэдээлэл байршуулах зэсийг үүсгээгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 "Байгууллага нь шилэн дансны мэдээллийг өөрийн цахим хуудсаар хүргэх бөгөөд цахим хуудас нь дараах шаардлагыг хангасан байна" 5.1.1 "шилэн дансны бие даасан цэстэй байх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны цахим мэдээллийн санд мэдээлэл байршуулах цэсийг үүсгэж, шилэн дансны тухай хуулийн дагуу мэдээлэх мэдээг тухай бүр байршуулж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

БОЛОВСРУУЛСАН:

АУДИТОР Б.ЖАЛБАА

ХЯНАСАН:

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.БАТ-УНДРАА

АУДИТЫН МЕНЕЖЕР Б.ДАГВАСҮРЭН

2022.03.24

9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс									
							Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн асуудлаар																
1	Тохижилт үйлчилгээний алба	ЗАА-2022/06/СТА-ОНӨААТҮГ	Байгууллагын бүтэц орон тоог нарийвчлан тогтоогоогүй байна.	Байгууллагын бүтэц орон тоо, цалингийн єанг нарийвчлан тогтоож мөрдөж ажиллах	1	0									1	
			Байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж ажиллаагүй	Байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан баталж, тухайн тайланд онд орох орлого, зардлын төсвийг ТУЗ-өөр батлуулан мөрдөж ажиллах	1	0									1	
			Байгууллагын үйл ажиллагааны орлогыг данс бүртгэлд тушаагаагүй байна.	Байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогыг харилцах дансанд тухай бүр тушааж байх.	1	0									1	
			Шилэн дансны тухай хуулийн дагуу шилэн дансны цахим сайтад мэдээлэл байршуулах зэсийг үүсгээгүй байна	Шилэн дансны цахим мэдээллийн санд мэдээлэл байршуулах цэсийг үүсгэж, шилэн дансны тухай хуулийн дагуу мэдээлэх мэдээг тухай бүр байршуулж ажиллах	1	0									1	
			Санхүүгийн тайланд авлага, өглөгийг зөрүүтэй тусгасан	Авлага өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж, балансад тусгах	1	822.1	1	822.1								
ДҮН					5	822.1	1	822.1							5	
Санхүүгийн тайлангийн асуудлаар шалгасан нийцлийн асуудал																
ДҮН																
НИЙТ ДҮН					5	822.1	1	822.1							5	